



### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор сумын 14 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2021/183/СТА-ТШЗ

Баянхонгор 2021 он	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер: А.Цээням Утас: 88011833 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: Г.Ганчимэг Утас: 88268424 Цахим хаяг: ganaa_7133@yahoo.com Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a>
-----------------------	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

**Агуулга**

1.Төрийн аудитын санал, дүгнэлт /Эх хувь/.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
3.Аудитын тайлан .....	11
3.1. Ерөнхий зүйл .....	11
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй .....	11
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт .....	11
3.4. Материаллаг байдал .....	12
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	12
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт .....	13
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	14
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
3.9. Аудитын илрүүлэлт.....	15
Залруулсан алдаа.....	15
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил .....	15
Аудитын зөвлөмж.....	15
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд .....	15
4. Менежментийн захидал.....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	17



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,  
Баянхонгор сум, Номгон баг  
Утас, факс 7044 2584  
E-mail; bayankhongor@audit.gov.mn

Г БАЯНХОНГОР СУМЫН 14 ДҮГЭЭР Г  
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ Г  
Ө.ОЮУНГЭРЭЛ ТАНАА

2021. 02. 15 № 2/26  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г **Аудитын гэрчилгээ** Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор сумын 14 дүгээр цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Баянхонгор сумын 14 дүгээр цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор сумын 14 дүгээр цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн

2021 А4 ТООТ

• 005020898

систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

### Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД ТӨРГҮҮЛЭХ  
АУДИТОР Б.МӨНХБАТ



## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>19,192,373.86</b>	<b>23,893,254.30</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	30,901.00	12,600.72
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	12,600.72
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	30,901.00	00.00
3351	Байгууллагаас авах авлага	30,901.00	00.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	19,161,472.86	23,880,653.58
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	2,510,276.00	4,267,276.00
35110	Тусгай зориулалттай материал	2,510,276.00	3,777,276.00
35130	Эм боох материал	00.00	490,000.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	16,651,196.86	19,613,377.58
35410	Бичиг хэргийн материал	241,750.00	910,950.00
35420	Аж ахуйн материал	10,100,717.00	13,025,619.00
35450	Барилгын засварын материал	1,367,000.00	1,367,000.00
35460	Хүнсний материал	2,362,029.86	108.58
35470	Бусад хангамжийн материал	2,579,700.00	4,309,700.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>356,073,982.78</b>	<b>352,666,245.69</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	356,073,982.78	352,666,245.69
<b>392</b>	<b>Бнет хөрөнгө</b>	355,441,482.87	351,940,245.82
39201	Барилга, байгууламж, орон сууц	335,527,366.00	335,527,366.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-5,475,627.06	-13,187,679.30
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	22,624,870.00	32,103,370.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-10,006,368.33	-14,899,680.07
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	19,483,534.00	22,983,534.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-6,712,291.74	-10,586,664.81
<b>393</b>	<b>Бнет бус хөрөнгө</b>	632,499.91	725,999.87
39301	Програм хангамж	1,078,000.00	1,408,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-445,500.09	-682,000.13
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III-I+II</b>	<b>375,266,356.64</b>	<b>376,559,499.99</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>375,266,356.64</b>	<b>376,559,499.99</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	375,266,356.64	376,559,499.99
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	182,999,803.27	184,292,946.62
51210	Өмнөх үеийн үр дүн	182,999,803.27	182,999,803.27
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	1,293,143.35
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	192,266,553.37	192,266,553.37
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>375,266,356.64</b>	<b>376,559,499.99</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>218,675,500.00</b>	<b>281,527,600.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>4,602,500.00</b>	<b>6,445,500.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>4,602,500.00</b>	<b>6,445,500.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,602,500.00	6,445,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,500.00	00.00

**Баянхонгор сумын 14 дүгээр цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	4,600,000.00	6,445,500.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>214,073,000.00</b>	<b>275,082,100.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	200,094,300.00	258,405,900.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>13,978,700.00</b>	<b>16,676,200.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	13,978,700.00	16,676,200.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>218,327,658.36</b>	<b>280,234,456.65</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>218,327,658.36</b>	<b>280,234,456.65</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>218,251,563.36</b>	<b>277,302,059.56</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>143,283,123.00</b>	<b>187,545,844.19</b>
210101	Үндсэн цалин	142,903,082.00	148,324,476.28
210102	Нэмэгдэл	00.00	30,559,263.59
210104	Урамшуулал	380,041.00	7,853,123.05
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	808,981.27
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>17,910,232.00</b>	<b>23,476,500.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	12,687,600.00	15,964,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,511,801.00	1,878,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	985,200.00	1,502,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	263,200.00	364,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,462,431.00	3,767,100.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>11,178,700.00</b>	<b>14,816,064.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,049,142.00	6,005,046.00
210302	Түлш, халаалт	2,908,178.00	3,814,918.00
210303	Цэвэр, бохир ус	5,221,380.00	4,996,100.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>2,297,300.00</b>	<b>4,901,593.00</b>
210401	Бичиг хэрэг	69,000.00	1,247,900.00
210402	Тээвэр, шатахуун	162,100.00	600,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	884,479.00	866,793.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	195,000.00	358,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	986,721.00	1,828,900.00
<b>2105</b>	<b>Норматив зардал</b>	<b>24,348,426.66</b>	<b>26,811,021.28</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	50,700.00	624,200.00
210502	Хоол, хүнс	24,297,726.66	26,186,821.28
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,884,000.00</b>	<b>2,169,700.00</b>
210604	Урсгал засвар	1,884,000.00	2,169,700.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>00.00</b>	<b>103,600.00</b>
210702	Дотоод албан томилолт	00.00	103,600.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,039,700.00</b>	<b>470,900.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	839,700.00	220,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200,000.00	250,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>16,310,081.70</b>	<b>17,006,837.09</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	170,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,769,100.00	120,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	13,540,981.70	16,716,237.09

Баянхонгор сумын 14 дүгээр цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	76,095.00	2,932,397.09
2132	Бусад урсгал шилжүүлэг	66,300.00	110,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	66,300.00	110,700.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	9,795.00	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,795.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	371,416.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	371,416.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	2,450,281.09
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	2,450,281.09
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<b>347,841.64</b>	<b>1,293,143.35</b>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<b>347,841.64</b>	<b>1,293,143.35</b>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /Төгрөгөөр/
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>214,075,500.00</b>	<b>275,082,100.00</b>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,500.00	00.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,500.00	00.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,500.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,500.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	214,073,000.00	275,082,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	200,094,300.00	258,405,900.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	13,978,700.00	16,676,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	13,978,700.00	16,676,200.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>214,075,500.00</b>	<b>275,082,100.00</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	214,075,500.00	275,082,100.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	213,999,405.00	272,149,702.91
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	143,283,123.00	187,527,543.91
210101	Үндсэн цалин	130,115,024.00	149,433,913.34
210102	Нэмэгдэл	5,876,753.00	23,299,675.52
210104	Урамшуулал	7,291,346.00	13,690,700.76
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	1,103,254.29
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	17,910,232.00	23,476,500.00
210201	Тэтгэврийн даатгал	12,984,900.00	15,964,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,231,501.00	1,878,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	985,200.00	1,502,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	246,200.00	364,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,462,431.00	3,767,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,178,700.00	15,304,784.00
210301	Гэрэл, цахилгаан	3,049,142.00	6,493,766.00
210302	Түлш, халаалт	2,908,178.00	3,814,918.00
210303	Цэвэр, бохир ус	5,221,380.00	4,996,100.00

**Баянхонгор сумын 14 дүгээр цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>2,234,800.00</b>	<b>4,498,475.00</b>
210401	Бичиг хэрэг	41,500.00	99,900.00
210402	Тээвэр, шатахуун	162,100.00	600,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	884,479.00	1,084,875.00
210404	Ном, хэвлэл	00.00	51,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	195,000.00	358,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	951,721.00	2,304,000.00
<b>2105</b>	<b>Норматив зардал</b>	<b>27,490,150.00</b>	<b>26,206,600.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	30,900.00	651,700.00
210502	Хоол, хүнс	25,482,150.00	23,824,900.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,977,100.00	1,730,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>3,591,600.00</b>	<b>2,169,700.00</b>
210604	Урсгал засвар	3,591,600.00	2,169,700.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>00.00</b>	<b>103,600.00</b>
210702	Дотоод албан томилолт	00.00	103,600.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,014,700.00</b>	<b>800,900.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,814,700.00	550,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200,000.00	250,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>6,296,100.00</b>	<b>4,001,600.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	616,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,296,100.00	3,385,500.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>76,095.00</b>	<b>2,932,397.09</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>66,300.00</b>	<b>110,700.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	66,300.00	110,700.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>9,795.00</b>	<b>00.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,795.00	00.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>00.00</b>	<b>371,416.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	371,416.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>00.00</b>	<b>2,450,281.09</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	2,450,281.09
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>00.00</b>	<b>8,060,000.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>00.00</b>	<b>8,060,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>00.00</b>	<b>8,060,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>00.00</b>	<b>8,060,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	8,060,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>00.00</b>	<b>-8,060,000.00</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>


Баянхонгор сумын 14 дүгээр цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/ төгрөгөөр /	
					Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	192,266,553.37	182,999,803.27	00.00	375,266,356.64
D01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	192,266,553.37	182,999,803.27	00.00	375,266,356.64
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	192,266,553.37	182,999,803.27	00.00	375,266,356.64
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	1,293,143.35	00.00	1,293,143.35
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	192,266,553.37	184,292,946.62	00.00	376,559,499.98

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	/ төгрөгөөр /	
		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	275,082,100.00	272,260,402.91
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	275,082,100.00	272,260,402.91
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	274,971,400.00	272,149,702.91
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	187,811,300.00	187,527,543.91
210101	Үндсэн цалин	149,513,800.00	149,433,913.34
210102	Нэмэгдэл	23,114,300.00	23,299,675.52
210104	Урамшуулал	13,827,700.00	13,690,700.76
210105	Гэрээт ажлын хөлс	1,355,500.00	1,103,254.29
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	23,476,500.00	23,476,500.00
210201	Тэтгэврийн даатгал	15,964,000.00	15,964,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,878,100.00	1,878,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,502,500.00	1,502,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	375,600.00	364,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,756,300.00	3,767,100.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	15,676,200.00	15,304,784.00
210301	Гэрэл, цахилгаан	6,770,500.00	6,493,766.00
210302	Түлш, халаалт	3,905,700.00	3,814,918.00
210303	Цэвэр, бохир ус	5,000,000.00	4,996,100.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	5,091,200.00	4,498,475.00
210401	Бичиг хэрэг	99,900.00	99,900.00
210402	Тээвэр, шатахуун	600,000.00	600,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,388,000.00	1,084,875.00
210404	Ном, хэвлэл	55,300.00	51,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	644,000.00	358,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,304,000.00	2,304,000.00



Баянхонгор сумын 14 дүгээр цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

<b>2105</b>	<b>Норматив зардал</b>	<b>26,209,400.00</b>	<b>26,206,600.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	651,700.00	651,700.00
210502	Хоол, хүнс	23,827,700.00	23,824,900.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,730,000.00	1,730,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>4,690,700.00</b>	<b>3,169,700.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,521,000.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	2,169,700.00	2,169,700.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>103,600.00</b>	<b>103,600.00</b>
210702	Дотоод албан томилолт	103,600.00	103,600.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>850,900.00</b>	<b>800,900.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	550,900.00	550,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	250,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>11061600.00</b>	<b>11061600.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,676,100.00	7,676,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,385,500.00	3,385,500.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>110700.00</b>	<b>110700.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>110,700.00</b>	<b>110,700.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	110,700.00	110,700.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>275,082,100.00</b>	<b>272,260,402.91</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>258,405,900.00</b>	<b>255,955,618.91</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	258,405,900.00	255,955,618.91
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>16,676,200.00</b>	<b>16,304,784.00</b>
132001	Орон нутгийн төсвөөс	16,676,200.00	16,304,784.00
610001	Төсвийн байгууллага	1	1
610002	Төсвөөс гадуур байгууллага	00	00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>17</b>	<b>22</b>
620001	Удирдах ажилтан	01	01
620002	Гүйцэтгэх ажилтан	10	11
620003	Үйлчлэх ажилтан	06	10
620004	Гэрээт ажилтан	00	01
<b>63</b>	<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>	<b>147</b>	<b>108</b>
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	1	1
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>17</b>	<b>21</b>
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	11	11
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	06	09
650010	Гэрээт ажилтан	00	01

### **3.Аудитын тайлан**

#### **3.1. Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор сумын 14 дүгээр цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг эрхлэгч Ө.Оюунгэрэл танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд төсвийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах, үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 10-аас 2021 оны 02 дугаар сарын 12-ний хооронд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Ганчимэг хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор аймгийн 14 дүгээр цэцэрлэг нь 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 14/70 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй**

Баянхонгор сумын 14 дүгээр цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Цэцэрлэгийн сургалт, үйл ажиллагааны төлөвлөлт, зохион байгуулалт, хүүхэд болон багшийн хөгжлийг дэмжих, эрүүл, аюулгүй, хүртээмжтэй сургалтын орчин бүрдүүлэх, эцэг, эх, асран хамгаалагчийн оролцоо, хамтын ажиллагааг хангах.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна. Дараах хууль тогтоомжийг мөрдөж байна.

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хууль
- Татварын багц хуулиуд
- Нийгмийн даатгалын тухай хууль

#### **3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт**

Баянхонгор сумын 14 дүгээр цэцэрлэгийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба 2020 онд харьяа орон нутаг дахь Баянхонгор сумын 14 дүгээр цэцэрлэгийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Баянхонгор сумын 14 дүгээр цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Тус байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны 3 дугаар улирлын үр дүнгийн тайлангийн нийт зардал 181708,8 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 3634,1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 280234,4 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 5604,6 мянган төгрөгөөр тооцов.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Баянхонгор сумын 14 дүгээр цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 376559,5 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 1293,1 мянган төгрөгөөр буюу 0,3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>19,192.4</b>	<b>23,893.3</b>	<b>4,700.9</b>
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	30.9	12.6	(18.3)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	19,161.5	23,880.7	4,719.2
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>356,074.0</b>	<b>352,666.2</b>	<b>(3,407.7)</b>
Үндсэн хөрөнгө	378,713.8	392,022.3	13,308.5
Хуримтлагдсан элэгдэл	(22,639.8)	(39,356.0)	(16,716.2)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>375,266.4</b>	<b>376,559.5</b>	<b>1,293.1</b>
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	375,266.4	376,559.5	1,293.1
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>375,266.4</b>	<b>376,559.5</b>	<b>1,293.1</b>


Эх сурвалж: Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан

Авлагын дансны үлдэгдэл 12,6 мянган төгрөг болж 18,3 мянган төгрөгөөр буурсан нь байна өмнөх оны авлагыг бүрэн барагдуулсан ба тайлант онд нийгмийн даатгалын шимтгэлийг илүү тооцож шилжүүлснээс авлага үүссэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 23880,6 мянган төгрөг болж 4719,2 мянган төгрөгөөр өссөн нь Дэлхийн зөн олон улсын байгууллагаас өгсөн 1197,0 мянган төгрөгийн хөрөнгө, төсвийн хөрөнгөөр худалдаж авсан эргэлтийн хөрөнгө нэмэгдсэнээс голлох нөлөөг үзүүлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 392022,2 мянган төгрөг болж 13308,5 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 8060,0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, хандив тусламжаар 5248.5 мянга төгрөгийн хөрөнгө бүртгэсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс нь Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны яамны хөрөнгө оруулалтаар үнэ төлбөргүй ирсэн 5248.5 мянга, урсгал төсвийн худалдан авалтаар 8060,0 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.



Баянхонгор сумын 14 дүгээр цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 376559,5 мянган төгрөг болж 1293,1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 1293,1 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 281527,6 мянган төгрөг болж, өмнөх оноос 62852,1 мянган төгрөгөөр буюу 28,7 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан төсөвт байгууллагын өөрийн орлого, тусламж санхүүжилтийн орлого байна. Төсөв байгууллагын өөрийн орлого өмнөх оноос 1843,0 мянган төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй хүлээж авсан орлого нэмэгдсэн, тусламж санхүүжилтийн орлого 61009,1 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт 58331,6 мянга, орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилт 2697,5 мянган төгрөгөөр санхүүжилт нэмэгдсэнтэй холбоотой байна.

Нийт зардал 280234,4 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 61906,7 мянган төгрөгөөр буюу 28,3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, НДШ, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, норматив зардал, хангамж бараа материалын зардал, бараа үйлчилгээний бусад зардлууд нэмэгдсэнтэй холбоотой байна

### **3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 477696.9 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 477696.9 мянган төгрөгөөр тооцон суралцагчдын тоог 100, ажиллагсдыг 15 орон тоогоор төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 186426.8 мянган төгрөгөөр бууруулж 291270.1 мянган төгрөгөөр, суралцагчдын тоог 147, ажиллагсдыг 17 орон баталсан байна. Цалин, НДШ, гэрэл цахилгаан, цэвэр бохир ус тавилга, урсгал засварын зардлыг бууруулан баталсан байна.


#### **Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 275082,1 мянган төгрөгийн төсөв баталснаас 258405,9 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээр 16676,2 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээс 258405,9 мянга, орон нутгийн төсвөөс 16676,2 мянган төгрөгийн санхүүжилт авч, нийт 275082,1 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 272260,4 мянган төгрөгийг зарцуулж 2821,6 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 272260,4 мянган төгрөг буюу 99,0 хувьтай байгаа нь цалингийн зардлыг 2821,6 мянга, байр ашиглалттай холбоотой тогтол зардлыг 371,4 мянга, хангамж бараа материалын зардлыг 592,7 мянга, эд хогшил, урсгал засварын зардлыг 1521,0 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг 2821,6 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан нь зарцуулсан нь 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээний зардлыг 15671,9 мянган төгрөгийг зарцуулаагүйтэй холбоотой байна.



Баянхонгор сумын 14 дүгээр цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Хүснэгт-2 Төсвийн гүйцэтгэлийн бүлэгтэй

/төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>ХӨТӨЛБӨР 71801</b>				
<b>АРГА ХЭМЖЭЭ 81834</b>				
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	275,082,100.00	272,260,402.91	2,821,697.09	98.97
УРСГАЛ ЗАРДАЛ	275,082,100.00	272,260,402.91	2,821,697.09	98.97
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	275,082,100.00	272,260,402.91	2,821,697.09	98.97
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	173,983,600.00	173,836,843.15	146,756.85	99.92
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,748,000.00	21,748,000.00	0.00	100.00
Хангамж, бараа материалын зардал	3,547,200.00	3,240,475.00	306,725.00	91.35
Норматив зардал	2,381,700.00	2,381,700.00	0.00	100.00
Эд хогшил, урсгал засварын зардал	2,169,700.00	2,169,700.00	0.00	100.00
Томиллот, зочны зардал	103,600.00	103,600.00	0.00	100.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	850,900.00	800,900.00	50,000.00	94.12
Бараа үйлчилгээний бусад зардал	11,061,600.00	11,061,600.00	0.00	100.00
<b>ХӨТӨЛБӨР 71801</b>				
<b>АРГА ХЭМЖЭЭ 81835</b>				
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	18,621,200.00	16,677,200.76	1,943,999.24	89.56
УРСГАЛ ЗАРДАЛ	18,621,200.00	16,677,200.76	1,943,999.24	89.56
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	18,621,200.00	16,677,200.76	1,943,999.24	89.56
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	13,827,700.00	13,690,700.76	136,999.24	99.01
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,728,500.00	1,728,500.00	0.00	100.00
Хангамж, бараа материалын зардал	1,544,000.00	1,258,000.00	286,000.00	81.48
Норматив зардал	1,521,000.00		1,521,000.00	0.00
<b>ХӨТӨЛБӨР 71801</b>				
<b>АРГА ХЭМЖЭЭ 80109</b>				
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	16,676,200.00	16,304,784.00	371,416.00	97.77
УРСГАЛ ЗАРДАЛ	16,676,200.00	16,304,784.00	371,416.00	97.77
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	16,676,200.00	16,304,784.00	371,416.00	97.77
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,676,200.00	15,304,784.00		
Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	1,000,000.00	0.00	100.00
<b>ХӨТӨЛБӨР 71801</b>				
<b>АРГА ХЭМЖЭЭ 81807</b>				
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	23,827,700.00	23,824,900.00	2,800.00	99.99
УРСГАЛ ЗАРДАЛ	23,827,700.00	23,824,900.00	2,800.00	99.99
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	23,827,700.00	23,824,900.00	2,800.00	99.99
Хоол, хүнс	23,827,700.00	23,824,900.00	2,800.00	99.99
<b>ХӨТӨЛБӨР 71801</b>				
<b>АРГА ХЭМЖЭЭ 80802</b>				
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	110,700.00	110,700.00	0.00	100.00
Бусад урсгал шилжүүлэг	110,700.00	110,700.00	0.00	100.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	110,700.00	110,700.00	0.00	100.00

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn)

цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны тухай хуулийн дагуу байршуулбал зохих 151 мэдээллээс 149 мэдээллийг байршуулсан. Үүнээс хугацаа хоцорсон 2, байршуулах хугацаа болоогүй 2 мэдээлэл байна. Цалингийн зардлаас

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд нь байршуулсан	Хугацаа хоцроож байршуулсан	Байршуулаагүй	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	9	0	0	2
2	Хагас жил	4	4	4	0		
3	Улирал бүр	1	4	4	0		
4	Сар бүр	3	36	36	0		
5	Тухай бүр	8	96	94	2		
	Нийт	27	151	147	2	0	2

Баянхонгор сумын 14 дүгээр цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 28857,0 мянган төгрөгийн орлогын гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1184,4 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоосныг 2020 оны 03 дугаар сарын 30 ний өдөр төлж хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Хүснэгт-4

/мянган.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	1184,4	1	1184,4			
Нийт дүн	1	1184,4	1	1184,4			

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 38538,1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 492,5 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 38045,6 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

#### Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

#### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 492,5 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрч 1 төлбөрийн акт тогтоолоо. Үүнд:

Хоолны зардлыг тулган шалгахад багшийн журналын ирцээр 5165 хүүхэд өдөр байхад меню, нярвын тайлангаар 5364 хүүхэд өдрөөр зарлага гаргаж 199 хүүхэд өдрөөр илүү зарцуулалт гаргаж 492,5 мянган төгрөгийг хоолны зардлаас илүү зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", "Үнэн зөв байдал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоож төлүүлэхээр шийдвэрлэв.

#### Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 38045,6 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### 3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД


Байхгүй.

### 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### 1. Удирдлагын дээд болон дотоод хяналттай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 2020 онд нийт 151 мэдээлэл оруулахаас тухай бүр оруулахаас цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 28857,0 мянган төгрөгийн орлогын гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" 6.4 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэсэн заалтыг зөрчсөн.



Баянхонгор сумын 14 дүгээр цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**1.2 Эрсдэл:** Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлээгүй байх.

**1.3 Өгсөн зөвлөмж:** Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т заасан мэдээллүүдээс цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээний мэдээллүүдийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчлийг арилган, цаашид хуулийг хэрэгжүүлж ажиллах.

**1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

## **2. Зардлын данстай холбоотой асуудал**

**2.1. Илрүүлэлт:** 2020 оны төсвийн төсөлд 3 бүлэгтэй 15 орон тоотой ажиллахаар төлөвлөж, төслийг хүргүүлсний дараа тус цэцэрлэгт 3,6 дугаар багт амьдардаг эмзэг бүлгийн хүүхдүүдийг цэцэрлэгт хамруулахаар гэр цэцэрлэгийг нэмж байгуулан тухайн цэцэрлэгт хариуцуулж орон тоог 17 байхаар баталж өгсөн байна. Төсвийн төлөвлөлтийг хийхдээ арга зүйч, дуу хөгжмийн багш, 2 жижүүр гэсэн орон тоог төлөвлөөгүй 21 орон тоотой ажиллаж орон тоог 4-өөр хэтрүүлэн цалинд 37847,6 мянган төгрөгийг зарцуулж, хоолны зардлаас цалингийн зардалд 14368,5 мянган төгрөгийг нэмж 2020 онд зохицуулалт хийлгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.3 "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох" гэсэн заалттай нийцэхгүй байна.

**2.2. Эрсдэл:** Зардал хэтрэх өр авлага үүсэх, төсвийг бүлэгт хооронд зөвшөөрөлгүй гүйлгэн зарцуулсан байх.

**2.3. Өгсөн зөвлөмж:** Төсвийн төлөвлөлтөд орон тоо, цалингийн санг үндэслэлтэй төлөвлөж, орон тоо батлагдаагүй байхад илүү орон тоогоор ажиллуулж байгааг цаашид зогсоож, төсвийг бүлэг хооронд шилжүүлэн зарцуулахгүй Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.3 дахь "Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах.

**2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

## **3. Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл**


**3.1. Илрүүлэлт:** Биет бус хөрөнгийн дансанд 2018 онд санхүүгийн программ сунгалтын төлбөр 198,0 мянган төгрөгийг орлого авч хөрөнгөөр бүртгэсэн нь Сангийн сайдын 2006 оны 11 дүгээр сарын 28 ний өдрийн 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт "Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар" 4.47 "Биет бус хөрөнгөнд патент, гудвилл, франчайз, зохиогчийн эрх, лиценз, программ хангамж, судалгаа хөгжүүлэлтийн зардал зэрэг хамрагдана" НББОУС 38 Биет бус хөрөнгө стандарт, "Оршин байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**3.2. Эрсдэл:** Биет бус хөрөнгийн дансанд хөрөнгийг буруу ангилан бүртгэх.

**3.3. Өгсөн зөвлөмж:** Санхүүгийн программын сунгалтын төлбөрийг биет бус хөрөнгөөр хүлээн зөвшөөрч бүртгэхгүй байх, Нягтлан бодох бүртгэлийн заавар журмыг мөрдөж хөрөнгө, зардлыг стандартын дагуу ангилж бүртгэх.

**3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.



Баянхонгор сумын 14 дүгээр цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт**

Огноо	Аудитын нэр:	Баянхонгор сумын 14 дүгээр цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит			Аудитын код:
2020					БНА-2021/183/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:		Баянхонгор сумын 14 дүгээр цэцэрлэг			Мянган төгрөг
№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
A	1	2	3	4	5
1	Хоолны зардлаас журналын ирцээс 199 хүүхэд өдрөөр илүү зарцуулалт гаргаж 492,5 мянган төгрөгийг илүү зарцуулсан байна.	492.5	Төлбөрийн акт	Төсвийн захирагч, Нягтлан бодогч	Ө.Оюунгэрэл, Ж.Оюунгэрэл
2	Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 2020 онд нийт 151 мэдээлэл оруулахаас тухай бүр оруулахаас цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 28857,0 мянган төгрөгийн орлогын гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн.	0	Зөвлөмж өгөх	Төсвийн захирагч, Нягтлан бодогч	Ө.Оюунгэрэл, Ж.Оюунгэрэл
3	Тайлант онд 21 орон тоотой ажиллаж батлагдсан орон тоог 4-өөр хэтрүүлэн цалинд 37847,6 мянган төгрөгийг зарцуулж, хоолны зардлаас цалингийн зардалд 14368,5 мянган төгрөгийг нэмж 2020 онд зохицуулалт хийлгэсэн байна.	37847.6	Зөвлөмж өгөх	Төсвийн захирагч, Нягтлан бодогч	Ө.Оюунгэрэл, Ж.Оюунгэрэл
4	Биет бус хөрөнгийн дансанд 2018 онд санхүүгийн программ сунгалтын төлбөр 198,0 мянган төгрөгийг орлого авч хөрөнгөөр бүртгэсэн.	198,0	Зөвлөмж өгөх	Төсвийн захирагч, Нягтлан бодогч	Ө.Оюунгэрэл, Ж.Оюунгэрэл
<b>ДҮН</b>		<b>38538.1</b>			

**АУДИТЫН ТАЙЛАНГ:**

Бэлтгэсэн:  
АУДИТОР

Анхан шатанд хянасан:  
ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД АУДИТЫН  
МЕНЕЖЕР

Хоёр дахь шатанд хянасан:  
ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР

Г.ГАНЧИМЭГ  
Огноо: 2021.02.15

А.ЦЭЭНЯМ  
Огноо: 2021.02.15

Б.МӨНХБАТ  
Огноо: 2021.02.15

6417143544  
8040067 9007423